



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭД ДАРГА ХҮРЭЛБААТАРЫН
БУЛГАНТУЯА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2025.10.30 № 3Г-1/122
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тухай

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025. 10. 27 № ХЭГ/2971
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт ⁶⁸ хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

300255014463



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,


Цахим хуудас: www.mojha.gov.mn

2025.10.22 № 1/1882

ганай _____-ны № _____-т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД
Т.АУБАКИР ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Л.МӨНХБААТАР

А5.файл.2025
151602670



**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

Энхтайваны өргөн чөлөө 7а,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: 26 21 35, Факс: (976-11) 32 21 27

Цахим шуудан: info@mfa.gov.mn

Цахим хуудас: www.mfa.gov.mn

2025.10.21 № 01/5070
танай -ны № 01/3518 -т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9-д заасны дагуу “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгов.

Б.БАТЦЭЦЭГ

115251992



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn


2025.10.24 № 01/9610

танай _____-ны № _____-т

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД Т.АУБАКИР
ТАНАА

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгож байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН

9761002067

پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې

پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٧ ټولنیزو غړو،
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ١٤٢١٠، پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٦ ٢١ ٣٥،
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢ (٩٧٦-١١) پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢،
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢،
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢: www.mfa.gov.mm

پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢

پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢

پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢

پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢
 پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢

پورتال پمپاړۍ د ژغورنې د پرمختیا د کمیټې د ٢٧ ٢١ ٣٢



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 21 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“7.ХЭЛЭЛЦСЭН нь: “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

БАТЛАВ.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД

Т.АУБАКИР

БАТЛАВ.

ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД

Б.БАТЦЭЦЭГ

БАТЛАВ.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

Л.МӨНХБААТАР

2025 оны 09 сарын 08 -ний өдөр

**“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ТЭТГЭВРИЙН АСУУДЛААР ХАМТРАН
АЖИЛЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 3.1-д "Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ", "Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ" гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3.6-д "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулах" зорилт дэвшүүлсэнтэй уялдуулан гадаад улсад ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах, эрх ашгийг хамгаалах зорилгоор Монгол Улсын иргэд олноор оршин суудаг улстай нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийг байгуулах шаардлага үүссэн.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасны дагуу заавал соёрхон батлах олон улсын гэрээ байх бөгөөд Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлуулахаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн шаардлага бий болсон.

1.2.Практик шаардлага

Одоогийн байдлаар Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Чех Улс зэрэг 6 улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулж, иргэдийн шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцох, уг хугацаанд

ногдох тэтгэвэр тогтоолгон авах, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж авах нөхцөлийг бүрдүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар 1993 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай анхны хэлэлцээрийг байгуулсан бөгөөд Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газраас 2014 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр хэлэлцээрийг цуцлах санал ирүүлсний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 304 дүгээр тогтоолоор энэхүү хэлэлцээрийг цуцалсан. Хэлэлцээр цуцлагдсанаар хоёр улсын иргэд, үүнээс Монгол Улсын харьяатаас гарсан казах иргэдийн Монгол Улсад ажилласан, шимтгэл төлсөн хугацааг Казахстан Улсад тооцохгүй болж тэтгэвэр авах эрх нь үүсэхгүй байх, мөн бага хэмжээний тэтгэвэр тогтоогдох эрсдэл бий болсон.

Гадаад харилцааны яамны мэдээллээр 2023 оны байдлаар Бүгд Найрамдах Казахстан Улсад Монгол Улсын 8.0 мянган иргэн оршин сууж байгаагаас 3.1 мянган иргэн албан ёсоор ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Монгол Улсад Бүгд Найрамдах Казахстан Улсын 564 иргэн оршин сууж байна. Цаашид иргэд хоорондын зорчих хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан энэ тоо өсөх хандлагатай байна.

Иймээс улс орны нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, иргэдийн хүсэлт, Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол, Казахстаны Засгийн газар хоорондын комиссын хуралдаан (VI-IX), түүний мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд үндэслэн хоёр улсын Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн яамд 2018 оноос хамтран ажиллаж, 17 удаагийн хэлэлцээ хийснээр "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийн төслийг эцэслэн боловсруулсан.

Хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн, Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн дэмжиж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 89 дүгээр захирамжаар Хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад олгосноор сайд Л.Энх-Амгалан, Бүгд Найрамдах Казахстан Улсын Тэргүүн шадар сайд Скляр Роман Васильевич нар Улаанбаатар хотноо 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр хэлэлцээрт гарын үсэг зурсан.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл нь нэг зүйлтэй ба Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах тухай тусгана.

Хэлэлцээрт хоёр улсын иргэд дараах тохиолдолд тэтгэвэр тогтоолгохоор тусгасан. Үүнд:

- Хоёр улс өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоохдоо нөгөө талын нутаг дэвсгэрт 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл ажилласан (даатгуулсан) цаг хугацааны хувьд давхцаагүй хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр тогтоох;

- Монгол Улсын иргэд 1998 оноос хойш Бүгд Найрамдах Казахстан Улсын хуримтлалын тэтгэврийн санд шимтгэл төлж хамрагдсан бол Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжийн дагуу хуримтлалын тэтгэвэр тогтоолгох, Монгол Улс дахь банкны өөрийн дансанд хуримтлалын тэтгэврийг шилжүүлэн авах;

- Хэлэлцээрт хоёр улсын цэргийн алба хаасны тэтгэвэр хамаарахгүй байх зэрэг болно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүй үр дагавар

Хуулийн төсөл батлагдаж, хэлэлцээр хэрэгжсэнээр дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

1.1998 оноос өмнө Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсад ажилласан, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн хоёр улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоолгох;

2.1998 оноос хойш Бүгд Найрамдах Казахстан Улсад хуримтлалын тэтгэврийн санд шимтгэл төлсөн Монгол Улсын иргэн Бүгд Найрамдах Казахстан Улсын хуримтлалын тэтгэврийн сангаас тэтгэвэр тогтоолгон авах боломж бүрдэж тухайн хүний ирээдүйн нийгмийн хамгааллын баталгаа нь сайжирна.

Хоёр улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоож олгох тул нийгмийн даатгалын санд санхүүгийн илүү дарамт үүсэхгүй болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хууль батлагдсантай холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

--- оОо ---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар нь хилийн чанадад оршин сууж байгаа иргэдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 3.1-т "Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлнэ" гэж, мөн "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.1.3.6-д "Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулах" зорилт дэвшүүлсэн.

Түүнчлэн, Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол Улс, БНКУ-ын Засгийн газар хоорондын комиссын хуралдаан (VI-IX), түүний мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хоёр талаас нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шуурхай байгуулах талаар тэмдэглэсэн болно.

Энэ хүрээнд Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамтай хэлэлцээрийн төсөл боловсруулах асуудлаар Монгол Улсын Засгийн газар шинжээчдийн ажлын хэсгийг байгуулан ажиллаж 17 удаагийн хэлэлцээ хийж, Хэлэлцээрийн төслийн эцэслэн боловсруулсан.

Хоёр улс дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаснаар Хэлэлцээрт Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Бүгд Найрамдах Казахстан Улсын Тэргүүн шадар сайд Скляр Роман Васильевич нар Улаанбаатар хотноо 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурж, энэхүү хэлэлцээрийг албан ёсоор баталгаажуулаад байна.

Уг хэлэлцээр хэрэгжсэнээр хоёр улсын иргэд Монгол Улс болон БНКУ-д ажилласан, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн өндөр насны тэтгэвэр тогтоолгох, Монгол Улсын иргэд БНКУ-аас хуримтлалын тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдсэнээр тухайн хүний ирээдүйн нийгмийн баталгаа сайжрах юм.

Гадаад харилцааны яамны мэдээллээр 2023 оны байдлаар БНКУ-д Монгол Улсын 8,036 иргэн оршин сууж байгаагаас 3,115 иргэн албан ёсоор ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Гадаадын иргэн, харьяатын газрын мэдээллээр Монгол Улсад БНКУ-ын 564 иргэн оршин сууж байна.

Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан тул Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасны дагуу соёрхон батлах олон улсын гэрээ юм. Хэлэлцээрийг монгол, казах болон орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж, бүх эх бичвэрүүд адил хүчинтэй байхаар тусгасан.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан бөгөөд хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Хэлэлцээр соёрхон батлах тухай
хуулийн төслийн тухай*

Монгол Улсын Засгийн газраас гадаад улсад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах зорилгоор тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ирсний нэг нь Монгол Улсын иргэд олноор оршин суудаг улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулж, хэрэгжүүлж ирлээ.

Энэ хүрээнд Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улс болон Бүгд Найрамдах Чех Улстай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр байгуулан, иргэдийн шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр тогтоох эрх үүсгэх, шимтгэл төлсөн хугацаанд ногдох тэтгэврийг харилцан шилжүүлэх, нийгмийн хамгааллын тогтолцоонд давхар хамрагдахаас урьдчилан сэргийлэх, зарим богино хугацааны тэтгэмж авах талаар харилцан тохиролцон, хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улс (БНКУ)-ын Засгийн газар 1993 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай анхны хэлэлцээрийг байгуулсан бөгөөд БНКУ-ын Засгийн газраас 2014 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр хэлэлцээрийг цуцлах санал ирүүлсний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 304 дүгээр тогтоолоор энэхүү хэлэлцээрийг цуцалсан. Хэлэлцээр цуцлагдсанаар хоёр улсын иргэд, ялангуяа Монгол Улсын харьяатаас гарсан казах иргэдийн Монгол Улсад хөдөлмөрлөсөн, шимтгэл төлсөн хугацааг нөгөө талд тооцохгүй болж тэтгэвэр авах эрх нь үүсэхгүй байх, мөн бага хэмжээний тэтгэвэр тогтоогдох эрсдэл бий болсон.

Иймээс хоёр улсын иргэдийн нийгмийн хамгааллын баталгааг хангах, тэтгэвэр авах эрх үүсэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор БНКУ-ын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яам болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, хэлэлцээр шинээр байгуулах асуудлаар Монгол Улсын Засгийн газар 2018 оноос шинжээчдийн ажлын хэсгийг байгуулан ажиллаж 17 удаагийн хэлэлцээ хийсэн.

Түүнчлэн, Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёлын хамтын ажиллагааны Монгол Улс, БНКУ-ын Засгийн газар хоорондын комиссын хуралдаан (VI-IX), түүний мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хоёр талаас нийгмийн хамгааллын хэлэлцээрийг шуурхай байгуулах талаар тэмдэглэсэн болно.

Монгол Улсын харьяатаас 1994-2018 онд 61.6 мянган казах иргэн гарсан тоон мэдээлэл байдаг. Түүнчлэн 2001-2017 онд Монгол Улсын харьяатаас гарч БНКУ-ын иргэн болсон боловч буцаж Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон 1.7 мянган иргэн байна.

Гадаад харилцааны яамны мэдээллээр 2023 оны байдлаар БНКУ-д Монгол Улсын 8,036 иргэн оршин сууж байгаагаас 3,115 иргэн албан ёсоор ажил хөдөлмөр эрхэлж байгаа бол Гадаадын иргэн, харьяатын газрын мэдээллээр Монгол Улсад БНКУ-ын 564 иргэн оршин сууж байна.

“Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-т Үндсэн ойлголтууд, Хамаарах этгээд болон хамрах хүрээ, Тэтгэвэр тогтоох болон олгох, Ажилласан (даатгуулсан) хугацааг нэгтгэн

тооцох, Тэтгэврийг шилжүүлэх, Талуудын хамтын ажиллагаа, Хүний хувийн мэдээлэл, Төгсгөлийн заалтууд гэсэн 8 зүйлийг тусгасан бөгөөд хоёр улсын иргэдэд тэтгэвэр тогтоож олгоход дараах зарчмыг баримтлахаар тохиролцсон. Үүнд:

- Монголын талаас тэтгэврийн даатгалын сангаас олгох газрын доор, хөдөлмөрийн халуун, хортой, хүнд нөхцөлөөр эрт тогтоохоос бусад өндөр насны тэтгэвэр, Казахстаны талаас өндөр насны тэтгэврийн болон хуримтлалын тэтгэврийн төлбөр гэсэн тэтгэврийн төрлийг хамааруулах;
- Хоёр улс өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоохдоо нөгөө талын нутаг дэвсгэрт 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл ажилласан (даатгуулсан) цаг хугацааны хувьд давхцаагүй хугацааг нэгтгэн тооцож тэтгэвэр тогтоох;
- БНКУ-д 1998 оноос хойш ажилласан (даатгуулсан) хугацаанд ногдох хуримтлалын тэтгэврийг БНКУ-ын хууль тогтоомжийн дагуу тогтоож, олгох, Монгол Улсад байнга оршин суухаар гарсан тохиолдолд Монгол Улс дахь тэтгэвэр авагчийн дансанд тэтгэврийг шилжүүлэх;
- Энэхүү хэлэлцээрт хоёр улсын цэргийн алба хаасны тэтгэвэр хамаарахгүй байх.

Уг хэлэлцээр хэрэгжсэнээр хоёр улсын иргэд Монгол Улс болон БНКУ-д ажилласан, шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн өндөр насны тэтгэвэр тогтоолгох, Монгол Улсын иргэд БНКУ-аас хуримтлалын тэтгэврийг тогтоолгон авах боломж бүрдсэнээр тухайн хүний ирээдүйн нийгмийн баталгаа сайжрах юм.

Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд зааснаас өөр журмаар тэтгэврийн эрх үүсгэх, олгох харилцааг зохицуулсан тул Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасны дагуу соёрхон батлах олон улсын гэрээ юм. Хэлэлцээрийг монгол, казах болон орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдэж, бүх эх бичвэрүүд адил хүчинтэй байхаар тусгасан.

Олон улсын гэрээний тухай 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт заасны дагуу талууд хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, Казахстаны талаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 30-73 тоот ноот бичгээр эцэслэн тохиролцсон хэлэлцээрийн төслийг ирүүлсэн. Мөн Монголын талаас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Гадаад харилцааны яамаар уламжлуулан 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1251 дүгээр албан бичгээр Казахстаны талд эцэслэн тохиролцсон хэлэлцээрийн төслийг хүргүүлснээр талууд хэлэлцээрийн төслийн эх бичвэрийг харилцан солилцсон болно.

Олон улсын гэрээний тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу Хэлэлцээрийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр шийдвэрлэсэн. Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар Хэлэлцээрийн төслийг хэлэлцэн дэмжиж, Засгийн газарт гарын үсэг зурах эрх олгосны дагуу Ерөнхий сайдын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 89 дүгээр захирамжаар Хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад олгосон.

Түүнчлэн, Хэлэлцээрийн төслийг БНКУ-ын Засгийн газар 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр хэлэлцэн дэмжиж, улмаар 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн

441 дүгээр тогтоолоор БНКУ-ын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын сайдад хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг олгосон.

Хоёр улс дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаснаар Хэлэлцээрт Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Л.Энх-Амгалан, Бүгд Найрамдах Казахстан Улсын Тэргүүн шадар сайд Скляр Роман Васильевич нар Улаанбаатар хотноо 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурж, энэхүү хэлэлцээрийг албан ёсоор баталгаажуулаад байна.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран баталсан.

Иймд “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн болно.

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ТЭТГЭВРИЙН АСУУДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ
ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хооронд 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан "Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр"-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН
ТЭТГЭВРИЙН АСУУДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн Газар (цаашид "Талууд" гэх) тэтгэвэр тогтоох, олгох асуудлаар хамтын ажиллагааг хөгжүүлэх хүсэл эрмэлзлийг удирдлага болгон доор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов:

**Нэгдүгээр зүйл
Үндсэн ойлголтууд**

1. Энэхүү Хэлэлцээрийн зорилгоор дараах үндсэн ойлголтуудыг хэрэглэнэ:

"оршин суугаа улс" гэж тэтгэвэр тогтоолгох өргөдөл гаргагчийн нутаг дэвсгэрт нь байнга оршин сууж байгаа улсыг;

"хууль тогтоомж" гэж тэтгэвэр тогтоох, олгох асуудлыг зохицуулсан Талуудын улсын хууль, эрх зүйн бусад баримт бичгүүдийг;

"өргөдөл гаргагч" гэж тэтгэвэр тогтоолгохоор хандсан этгээдийг, эсхүл түүний нэрийн өмнөөс эрх ашгийг нь төлөөлөх итгэмжлэгдсэн этгээдийг;

"эрх бүхий байгууллага" гэж Талуудын энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлж буй байгууллагыг;

"оршин суугаа газар" гэж Талуудын улсын хууль тогтоомжийн дагуу байнга оршин суугаа газар гэж тодорхойлсон буюу хүлээн зөвшөөрсөн өргөдөл гаргагчийн байнга оршин суугаа газрыг;

"тэтгэвэр" гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 2-т заасан тэтгэврийн төлбөрийг;

"хүний хувийн мэдээлэл" гэж цахим, цаасан хэлбэрээр болон (эсхүл) өөр материаллаг тээгч дээр хадгалагдсан өргөдөл гаргагч (тэтгэвэр авагч)-д хамаарах өгөгдлийг;

Бүртгэлийн дугаар. 250-01

**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ**

ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын зургийн тайлал)

2025 оны 10 дугаар сарын 28

“тэтгэвэр авагч” гэж энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 2-т заасан тэтгэвэр тогтоолгосон этгээдийг;

“ажилласан (даатгуулсан) хугацаа” гэж ажилласан ба (эсхүл) тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа болон Талуудын улсын хууль тогтоомжид заасан бусад хугацааг;

“бүрэн эрхт байгууллага” гэж:

Монгол Улсын тухайд: Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг;

Бүгд Найрамдах Казахстан Улсын тухайд: Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамыг.

Аль нэг талын бүрэн эрхт байгууллагыг өөрчлөн зохион байгуулсан, эсхүл албан ёсны нэр нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн Тал нь нөгөө Талдаа дипломат шугамаар нэн даруй энэ тухай мэдэгдэх ба холбогдох эрх мэдлийг шилжүүлэх арга хэмжээ авна.

2. Энэхүү Хэлэлцээрт хэрэглэгдэж байгаа бусад ойлголтыг Талуудын улсын хууль тогтоомжид тодорхойлсон утгаар хэрэглэнэ.

Хоёрдугаар зүйл Хамаарах этгээд болон хамрах хүрээ

1. Энэхүү Хэлэлцээр нь нэг Талын улсын нутаг дэвсгэрт байнга оршин сууж байгаа бөгөөд нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт ажилласан (даатгуулсан) хугацаатай Талуудын улсын иргэдэд хамаарна.

2. Энэхүү Хэлэлцээр дараах төрлийн тэтгэвэрт хамаарна:

2.1. Монгол Улсын тухайд тэтгэврийн даатгалын сангаас олгох газрын доор, хөдөлмөрийн халуун, хортой, хүнд нөхцөлөөр эрт тогтоохоос бусад өндөр насны тэтгэвэр (цаашид “өндөр насны тэтгэвэр” гэх).

2.2. Бүгд Найрамдах Казахстан Улсын тухайд:

2.2.1. өндөр насны тэтгэврийн төлбөр;

2.2.2. тэтгэврийн албан журмын шимтгэл, мэргэжлийн тэтгэврийн албан журмын шимтгэлээр бүрдүүлэх тэтгэврийн хуримтлалаас тэтгэврийн насанд хүрэхэд олгох тэтгэврийн төлбөрүүд (цаашид “хуримтлалын тэтгэвэр” гэх).

3. Энэхүү зүйлийн 2-т заасан тэтгэврийг тогтоох ба олгох асуудлыг зохицуулж байгаа Талуудын улсын хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү

Бүртгэлийн дугаар. 250-02

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

2025 оны 10 дугаар сарын 28

Хэлэлцээрийн заалтуудтай зөрчилдөөгүй бол энэхүү Хэлэлцээрт нэгэн адил хамаарна.

4. Энэхүү Хэлэлцээр дараах тэтгэвэрт хамаарахгүй:

Монгол Улсын тухайд -цэргийн алба хаасны тэтгэвэр;

Бүгд Найрамдах Казахстан Улсын тухайд -алба хаасан хугацааны тэтгэврийн төлбөр.

5. Энэхүү Хэлэлцээр нь 1961 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн Дипломат харилцааны тухай Венийн конвенц болон 1963 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Консулын харилцааны тухай Венийн конвенцийн холбогдох заалтад нөлөөлөхгүй.

Гуравдугаар зүйл Тэтгэвэр тогтоох болон олгох

1. Талуудын улсын иргэдийн тэтгэврийг оршин сууж буй улсын хууль тогтоомжийн дагуу тогтоох ба олгоно.

2. Монгол Улсын өндөр насны тэтгэврийг Монгол Улсын нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан журам ба нөхцөлийн дагуу тэтгэврийн даатгалын сангаас олгоно.

3. Бүгд Найрамдах Казахстан Улсын өндөр насны тэтгэврийн төлбөрийг Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасан журам болон нөхцөлийн дагуу улсын төсвийн хөрөнгөнөөс олгоно.

4. Бүгд Найрамдах Казахстан Улсын хуримтлалын тэтгэврийг Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасан журам болон нөхцөлийн дагуу тэтгэврийн хуримтлалын нэгдсэн сангаас олгоно.

5. Тэтгэвэр шилжүүлэхтэй холбогдсон нийт зардлыг тэтгэвэр тогтоож буй Тал хариуцна.

6. Монгол Улсад өндөр насны тэтгэвэр тогтоолгох, Бүгд Найрамдах Казахстан Улсад өндөр насны тэтгэврийн төлбөр тогтоолгох өргөдлийг оршин суугаа улсын хууль тогтоомжид заасан шаардлагатай баримт бичгийг хавсарган оршин суугаа улсын эрх бүхий байгууллагад гаргана.

7. Бүгд Найрамдах Казахстан Улсад хуримтлалын тэтгэвэр тогтоолгох өргөдлийг Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасан шаардлагатай баримт бичгийг хавсарган аль нэг Талын эрх бүхий байгууллагад гаргана.

Бүртгэлийн дугаар. 210 - 03

МОНГОЛ УЛСЫН

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

20 оны дугаар сарын 28

Нэг Талын эрх бүхий байгууллагад тэтгэвэр тогтоолгох зорилгоор өргөдөл гаргасан өдрийг нөгөө Талын эрх бүхий байгууллагад тухайн өдөр өргөдөл гаргасантай адилтган үзнэ.

Монгол Улсын эрх бүхий байгууллагад өргөдөл гаргасан тохиолдолд эрх бүхий байгууллага нь уг өргөдлийн эх хувь болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаар баталгаажуулж хавсаргасан баримт бичгийн хуулбарыг Бүгд Найрамдах Казахстан Улсын эрх бүхий байгууллагад өргөдөл хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор илгээнэ. Өргөдлийн маягтыг Бүгд Найрамдах Казахстан улсын эрх бүхий байгууллага батална.

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд Талуудын эрх бүхий байгууллагын хооронд баримт бичгийг илгээх хугацааг өргөдөл хянан үзэх болон тэтгэвэр тогтоох тухай шийдвэр гаргах хугацаанд оруулахгүй.

Бүгд Найрамдах Казахстан Улсын эрх бүхий байгууллага нь өргөдлийг Бүгд Найрамдах Казахстан Улсын хууль тогтоомжид заасан хугацаанд авч үзнэ.

Дөрөвдүгээр зүйл **Ажилласан (даатгуулсан) хугацааг нэгтгэн тооцох**

1. Монгол Улсын өндөр насны тэтгэвэр, Бүгд Найрамдах Казахстан Улсын өндөр насны тэтгэврийн төлбөрийг тогтоохдоо нэг Талын эрх бүхий байгууллага нь нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт 1998 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл ажилласан (даатгуулсан) цаг хугацааны хувьд давхцаагүй хугацааг нэгтгэн тооцно.

2. Аль нэг Талын нутаг дэвсгэрт ажилласан (даатгуулсан) хугацааг ажилласан (даатгуулсан) тухайн Талын эрх бүхий байгууллагаас энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд заасан журмын дагуу баталгаажуулсан нөхцөлд тооцно.

3. Талуудын улсын нутаг дэвсгэрт цэргийн алба хаасан болон их ба (эсхүл) дээд сургуулийн дараах болон тусгай мэргэжлийн дунд боловсролын тогтолцооны сургуульд суралцсан, түүнчлэн оюун санааны (шашны) боловсролын байгууллагуудад суралцсан хугацааг тэтгэвэр тогтоосон Талын улсын хууль тогтоомжийн дагуу ажилласан (даатгуулсан) хугацаанд тооцно.

Тавдугаар зүйл **Тэтгэврийг шилжүүлэх**

1. Тэтгэвэр авагч Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад байнга оршин суухаар гарсан тохиолдолд хуримтлалын тэтгэврийг шилжүүлнэ.

Бүртгэлийн дугаар... 250-04

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

20 оны 6 дугаар сарын 28

2. Хуримтлалын тэтгэврийг гүйлгээ хийсэн өдрийн Бүгд Найрамдах Казахстан Улсын валютын албан ханшаар Монгол Улсын үндэсний валютад хөрвүүлж, тэтгэвэр авагчийн дансанд шилжүүлнэ.

Зургадугаар зүйл Талуудын хамтын ажиллагаа

1. Талуудын бүрэн эрхт байгууллагууд нь энэхүү Хэлэлцээрийн хамрах хүрээнд хамаарах хууль тогтоомжид орсон аливаа өөрчлөлт, түүнчлэн бүрэн эрхт байгууллага, эрх бүхий байгууллагуудын өөрчлөлтийн талаар харилцан мэдээлж байна.

2. Талуудын бүрэн эрхт болон эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчид нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэх зорилгоор хоёр Талд ээлжлэн уулзалт зохион байгуулах эрхтэй.

3. Нөгөө Талын улсын нутаг дэвсгэрт ажилласан (даатгуулсан) хугацааг баталгаажуулах зорилгоор, түүнчлэн тэтгэвэр тогтоох, олгох, зогсоох болон энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад асуудлаар нэмэлт мэдээлэл, баримт бичиг авах шаардлагатай тохиолдолд нэг Талын эрх бүхий байгууллага нь нөгөө Талын эрх бүхий байгууллагад хүсэлт гаргана.

Эрх бүхий байгууллага хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор хариуг илгээнэ. Заасан хугацаанд хариу илгээх боломжгүй тохиолдолд эрх бүхий байгууллага нь хүсэлт гаргасан эрх бүхий байгууллагад энэ тухайгаа мэдэгдэнэ.

Талуудын эрх бүхий байгууллага нь хүсэлтийн болон хүсэлтэд хариу өгөх нэгдсэн маягыг батална.

4. Тэтгэврийн хэмжээг өөрчлөх, тэтгэврийг түдгэлзүүлэх буюу тэтгэвэр олголтыг зогсоох нөхцөл байдал үүссэн, мөн хүний хувийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд Талуудын эрх бүхий байгууллагууд холбогдох мэдээлэл авснаас хойш ажлын 5 өдрийн дотор харилцан мэдэгдэх үүрэг хүлээнэ.

Долдугаар зүйл Хүний хувийн мэдээлэл

1. Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Талуудын хооронд хүний хувийн мэдээллийг дамжуулна. Уг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарах бөгөөд тухайн мэдээллийг зөвхөн энэхүү Хэлэлцээр болон хүний хувийн мэдээлэлтэй холбоотой Талуудын улсын хууль тогтоомжийн хүрээнд ашиглана.

2. Талуудын бүрэн эрхт байгууллага, эрх бүхий байгууллага нь хүний хувийн мэдээллийг Талуудын улсын хууль тогтоомжийн дагуу цуглуулж, боловсруулж, хадгалж, хамгаална.

Бүртгэлийн дугаар. 250-01

МОНГОЛ УЛСЫН

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТОВ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

2015 оны 10 дугаар сарын 28

Наймдугаар зүйл
Төгсгөлийн заалтууд

1. Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах ба хэрэглэхтэй холбоотой маргааныг Талууд зөвлөлдөх, хэлэлцэх замаар шийдвэрлэнэ.

2. Энэхүү Хэлэлцээрийг соёрхон батлах ба соёрхон баталсан тухайгаа Талуудын дипломат шугамаар бичгээр гаргасан хамгийн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрийн дараагийн 2 дахь сарын эхний өдөр энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр тусгай тэмдэглэл үйлдэх замаар энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба эдгээр нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.


4. Энэхүү Хэлэлцээрийг тодорхойгүй хугацаанд байгуулна.

Тал тус бүр нь энэхүү Хэлэлцээрийг дараагийн хуанлийн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн цуцлах эрхтэй бөгөөд энэ тухайгаа тухайн хуанлийн жил дуусахаас 6-аас доошгүй сарын өмнө нөгөө Талд дипломат шугамаар бичгээр мэдэгдэнэ.


5. Энэхүү Хэлэлцээр дуусгавар болсон тохиолдолд энэхүү Хэлэлцээрийн заалтуудын дагуу үүссэн эрх нь хүчинтэй хэвээр байна.

Энэхүү Хэлэлцээрийг ~~Улаанбаатар~~ 2024 оны 10 дүгээр сарын 19-ны өдөр монгол, казах болон орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд бүх эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Энэхүү Хэлэлцээрийн бичвэрүүдийн хооронд зөрүү гарах тохиолдолд Хэлэлцээрийн орос хэлээрх эх бичвэрийг хэрэглэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



Бүртгэлийн дугаар... 250-06

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

2025 оны 10 дугаар сарын 18



**СОГЛАШЕНИЕ МЕЖДУ
ПРАВИТЕЛЬСТВОМ МОНГОЛИИ
И
ПРАВИТЕЛЬСТВОМ РЕСПУБЛИКИ КАЗАХСТАН
О СОТРУДНИЧЕСТВЕ В ПЕНСИОННОЙ СФЕРЕ**

Правительство Монголии и Правительство Республики Казахстан (в дальнейшем именуемые «Стороны»), руководствуясь стремлением развивать сотрудничество по вопросам назначения и выплаты пенсий, договорились о нижеследующем:

**Статья 1
Основные понятия**

1. Для целей настоящего Соглашения используются следующие основные понятия:

«государство проживания» – государство, на территории которого постоянно проживает заявитель;

«законодательство» – законы и другие правовые акты государств Сторон, регулирующие вопросы назначения и выплаты пенсий;

«заявитель» – лицо, обратившееся за назначением пенсии, либо доверенное лицо, действующее от его имени и представляющее его интересы;

«компетентный орган» – учреждение и (или) организация Сторон, реализующие настоящее Соглашение;

«место жительства» – место постоянного проживания заявителя, определяемое или признаваемое в качестве такового в соответствии с законодательством государств Сторон;

«пенсии» – пенсионные выплаты, указанные в пункте 2 статьи 2 настоящего Соглашения;

Бүртгэлийн дугаар.

МОНГОЛ УЛСЫН

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын хэргийн тайлал)

20... оны... дугаар сарын...

«персональные данные» – сведения, относящиеся к заявителю (получателю пенсии), зафиксированные на электронном, бумажном и (или) ином материальном носителе;

«получатель пенсии» – лицо, которому назначена пенсия, предусмотренная пунктом 2 статьи 2 настоящего Соглашения;

«трудовой (страховой) стаж» – периоды работы и (или) уплаты страховых пенсионных взносов, а также иные периоды в соответствии с законодательством государств Сторон;

«уполномоченный орган»:

в Республике Казахстан – Министерство труда и социальной защиты населения Республики Казахстан;

в Монголии – Министерство семьи, труда и социальной защиты Монголии.

При изменении официального наименования или преобразования уполномоченного органа одной из Сторон такая Сторона незамедлительно уведомляет об этом другую Сторону по дипломатическим каналам и принимает меры по обеспечению соответствующего правопреемства.

2. Иные понятия, используемые в настоящем Соглашении, применяются в значениях, определенных законодательством государств Сторон.

Статья 2

Круг лиц и сфера применения

1. Настоящее Соглашение распространяется на граждан государств Сторон, постоянно проживающих на территории государства одной из Сторон и имеющих трудовой (страховой) стаж на территории государства другой Стороны.

2. Настоящее Соглашение распространяется на следующие виды пенсий:

2.1. в Республике Казахстан:

2.1.1. пенсионные выплаты по возрасту;

2.1.2. пенсионные выплаты по достижении пенсионного возраста из пенсионных накоплений, сформированных за счет обязательных пенсионных взносов, обязательных профессиональных пенсионных взносов (далее – накопительные пенсии);

2.2. в Монголии – пенсии по возрасту, выплачиваемые из страхового пенсионного фонда, за исключением досрочных пенсий лицам, работавшим на

Бүртгэлийн дугаар. 250-08

МОНГОЛ УЛСЫН

ГАЗААР ХАРИУЦААНЫ ТӨВ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

2025 оны 10 дугаар сарын 28

подземных работах, работах в горячих температурных условиях и на работах с вредными и тяжёлыми условиями труда (далее – пенсии по возрасту).

3. Изменения и дополнения, внесенные в законодательство государств Сторон, регулирующие вопросы назначения и выплаты пенсий, указанных в пункте 2 настоящей статьи, распространяются на настоящее Соглашение, если они не противоречат его положениям.

4. Настоящее Соглашение не распространяется на следующие пенсии:

в Республике Казахстан – пенсионные выплаты за выслугу лет;

в Монголии – пенсии за военную службу.

5. Настоящее Соглашение не влияет на соответствующие положения Венской конвенции о дипломатических сношениях от 18 апреля 1961 года и Венской конвенции о консульских сношениях от 24 апреля 1963 года.

Статья 3

Назначение и выплата пенсий

1. Назначение и выплата пенсий гражданам государств Сторон осуществляются по законодательству государства проживания.

2. Пенсионные выплаты по возрасту в Республике Казахстан выплачиваются за счёт средств республиканского бюджета в порядке и на условиях, предусмотренных законодательством Республики Казахстан.


3. Накопительные пенсии в Республике Казахстан выплачиваются единым накопительным пенсионным фондом в порядке и на условиях, предусмотренных законодательством Республики Казахстан.

4. Пенсии по возрасту в Монголии выплачиваются из страхового пенсионного фонда в порядке и на условиях, предусмотренных законодательством о социальном страховании Монголии.

5. Все расходы, связанные с переводом пенсий, несет Сторона, назначившая пенсию.

6. Заявление о назначении пенсионных выплат по возрасту в Республике Казахстан и пенсий по возрасту в Монголии с приложением необходимых документов, предусмотренных законодательством государства проживания, подается заявителем в компетентный орган государства проживания.

7. Заявление о назначении накопительных пенсий в Республике Казахстан с приложением необходимых документов, предусмотренных



законодательством Республики Казахстан, подается заявителем в компетентный орган любой из Сторон.

Дата подачи заявления в целях назначения пенсии в компетентный орган одной из Сторон приравнивается к дате его подачи в компетентный орган другой Стороны.

В случае подачи заявления в компетентный орган Монголии оригинал заявления и копии приложенных документов, заверенные компетентным органом Монголии, пересылаются в компетентный орган Республики Казахстан в течение 10 рабочих дней со дня приема заявления. Форма заявления утверждается компетентным органом Республики Казахстан.

Срок пересылки документов между компетентными органами Сторон в рамках реализации настоящего Соглашения не включается в срок рассмотрения заявления и принятия решения о назначении пенсии.

Компетентный орган Республики Казахстан обеспечивает рассмотрение заявления в сроки, установленные законодательством Республики Казахстан.

Статья 4

Суммарный учет трудового (страхового) стажа

1. При назначении пенсионных выплат по возрасту в Республике Казахстан и пенсий по возрасту в Монголии компетентный орган одной Стороны производит суммарный учёт не совпадающего по времени трудового (страхового) стажа, приобретённого до 1 января 1998 года на территории государства другой Стороны.

2. Трудовой (страховой) стаж, приобретённый на территории одной из Сторон, учитывается при условии подтверждения его компетентным органом этой Стороны в порядке, предусмотренном статьей 6 настоящего Соглашения.

3. Периоды воинской службы и периоды обучения в системе высшего и (или) послевузовского и среднего специального образования, а также духовных (религиозных) организациях образования на территории государств Сторон засчитываются в трудовой (страховой) стаж в соответствии с законодательством государства Стороны, назначившей пенсию.

Статья 5

Перевод пенсий

1. Перевод накопительной пенсии производится в случае выезда получателя из Республики Казахстан на постоянное место жительства в Монголию.

Бүртгэлийн дугаар. 250-10

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

2015 оны 10 дугаар сарын 28

2. Перевод накопительной пенсии осуществляется на счет получателя в национальной валюте Монголии, конвертируемой по официальному курсу валюты Республики Казахстан на день совершения операции.

Статья 6 Сотрудничество Сторон

1. Уполномоченные органы Сторон информируют друг друга обо всех изменениях в законодательстве, а также об изменении уполномоченных и компетентных органов, касающихся сферы применения настоящего Соглашения.

2. Представители уполномоченных и компетентных органов Сторон вправе организовывать встречи в целях обсуждения вопросов, касающихся реализации настоящего Соглашения, поочередно в каждой из Сторон.

3. В целях подтверждения трудового (страхового) стажа, приобретенного на территории государства другой Стороны, а также при необходимости получения дополнительных сведений, документов по вопросам назначения, выплаты, прекращения пенсий и другим вопросам, связанным с реализацией настоящего Соглашения, компетентный орган одной Стороны направляет запрос в компетентный орган другой Стороны.

Компетентный орган после получения запроса направляет ответ в течение 30 рабочих дней. При невозможности направления ответа на запрос в указанный срок компетентный орган уведомляет об этом компетентный орган, направивший запрос.

Единые формы запросов и ответов на них утверждаются компетентными органами Сторон.

4. В случае возникновения обстоятельств, влекущих изменение размера пенсии, приостановление или прекращение ее выплаты, изменения персональных данных компетентные органы Сторон обязаны извещать друг друга в течение 5 рабочих дней после получения соответствующих сведений.

Статья 7 Персональные данные

1. В целях реализации настоящего Соглашения между Сторонами передаются персональные данные. Такие данные относятся к конфиденциальной персональной информации и используются исключительно в рамках настоящего Соглашения и соответствующего законодательства государств Сторон в сфере персональных данных.

Бүртгэлийн дугаар... 250 - 11

МОНГОЛ УЛСЫН

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТӨВ АРХИВ

ХУУЛБАР ҮНЭН

(Албан тушаалын нэр)

(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)

2025 оны 10 сарын 25

2. Уполномоченные и компетентные органы Сторон осуществляют сбор, обработку, хранение, защиту персональных данных в соответствии с законодательством государств Сторон.

Статья 8

Заключительные положения

1. Споры, связанные с толкованием и применением настоящего Соглашения, разрешаются Сторонами путем проведения консультаций и переговоров.

2. Настоящее Соглашение подлежит ратификации и вступает в силу в первый день второго месяца, следующего с даты получения по дипломатическим каналам последнего из письменных уведомлений Сторон о ратификации.

3. Стороны по взаимному согласию в настоящее Соглашение могут вносить изменения и дополнения, которые оформляются отдельными протоколами и являются неотъемлемой частью настоящего Соглашения.

4. Настоящее Соглашение заключается на неопределенный срок.

Каждая Сторона вправе прекратить действие настоящего Соглашения с первого января следующего календарного года, письменно уведомив об этом другую Сторону по дипломатическим каналам не менее чем за 6 месяцев до истечения текущего календарного года.

5. В случае прекращения действия настоящего Соглашения права, возникшие в соответствии с положениями настоящего Соглашения, не теряют своей силы.

